



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР**

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Партизаны гудамж, Утас: 26 35 64, Факс: (976-11) 32 49 77,  
И-мэйл: doc@nema.mn, Вэбсайт: www.nema.mn

2019, 06, 07 № 1/1222  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ  
БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ДАРГА,  
ЗАХИРАГЧ НАРТ

Үүрэг хүргүүлэх тухай

Монгол Улсын хэмжээнд 2019 оны эхний 5 сарын байдлаар нийт 2608 удаа гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдол бүртгэгдэж, үүний улмаас 66 хүн амь насаа алдаж, 34 хүн гэмтэж бэртэн 24617 толгой мал, амьтан хорогдож, 5.5 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан. Үүнээс 4 аймаг, нийслэлийн 1 дүүргийн нутаг дэвсгэрт усны ослын 19 удаагийн тохиолдлын улмаас 10 хүн амь насаа алдсаны 2 нь хүүхэд байна.

Сүүлийн жилүүдэд цаг агаарын гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэж, манай орны ихэнх нутгаар усархаг бороо орж үер, усны аюулт үзэгдэл жилээс жилд нэмэгдэж байна.

Мөн 2019 оны эхний 5 сарын байдлаар зам тээврийн ослын 35 дуудлага ирсэн байна. Энэхүү дуудлагад Онцгой байдлын байгууллагаас 156 хүн, 21 техник хэрэгсэлтэй ажиллаж, тусламж үзүүлж 25 иргэнийг аварч, 16 иргэн нас барсан байна.

Иймээс Онцгой байдлын ерөнхий газраас үер, усны ослоос сэрэмжлүүлэх, зам тээврийн ослын үед иргэдэд мэдээлэл өгөх самбарыг "Улаанбаатар Зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГазраас баталсан стандартад нийцүүлэн аймаг тус бүр 8-10 (50 км бүрт 1 тэмдэг)-ыг байршуулахыг үүрэг болгож байна.

Нарийвчилсан мэдээллийг Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны хэлтэс (харилцах утас-92263000)-ээс холбогдож авна уу.

Хавсралт хуудастай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

00001393



